



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭЭДЭЭ

№103
/317/

2022.06.02

Цаг үе, үйл явдал

ТӨРИЙН ЦЭРГИЙН БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ЭНХИЙГ САХИУЛАГЧ ЭМЭГТЭЙ АЛБА ХААГЧДЫН ТӨЛӨӨЛӨЛД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Эх үрсийн баяр, Монгол Улс НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсынхаа нэр төрийг өндөрт өргөж, НҮБ-ын энхийг

дэмжих ажиллагаанд оролцсон төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын энхийг сахиулагч эмэгтэй алба хаагчдын төлөөлөлд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ МЦНХ-

ны байранд боллоо.

Арга хэмжээнд МЦНХ-ны Удирдах зөвлөлийн дарга Б.Энх-Амгалан, Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Тогоо, удирдах зөвлөлийн гишүүн Ж.Бумнанжид нар оролцож, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын эмэгтэй энхийг сахиулагчдын төлөөлөл болон 11 алба хаагчийг хүлээн авч, холбооны үйл ажиллагаатай танилцуулан халуун дотно яриа өрнүүлж, байгууллагын дурсгалын зүйл гардуулав. Хүндэтгэл арга хэмжээнд Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн салааны ахлагч, радио релений станцын дарга, ахлах ахлагч Э.Урансайхан, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн тренажерын дадлагын багш, ахлах ахлагч Б.Цацрал, Зэвсэгт хүчний жанжин штабын эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч, дэд хурандаа Б.Нарангэрэл, БХЯ-ны Үйлчилгээ аж ахуйн хэлтсийн ахлах

тогооч, ахлах ахлагч Б.Ганчимэг, Хилийн 0101 дүгээр ангийн шалгагч, ахлах ахлагч А.Одончимэг, ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын мэдээллийн тусгай бүлгийн аврагч холбоочин, ахлах ахлагч Э.Золзаяа, Тагнуулын ерөнхий газрын хэлтсийн орлогч дарга, дэд хурандаа Б.Сайнбуян, Төрийн тусгай хамгаалалтын газрын Үйлчилгээний тусгай тасгийн дарга, дэд хурандаа Х.Эрдэнэтуяа, Цагдаагийн ерөнхий газрын Гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч Ц.Эрдэнэхишиг, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын ахлах мэргэжилтэн, хошууч Ч.Дарьсүрэн, Хорих 401 дүгээр хаалттай ангийн эрүү нүүрний мэс заслын их эмч, хошууч Б.Наранчимэг нар оролцлоо.

ШҮХЭРЧИН ДАЙЧИД “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ”-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 084 дүгээр анги

“Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн бүрэлдэхүүн 5 дугаар сарын 31-ний өдөр ангийн бүрэлдэхүүнийхээ гэр бүлийнхэн, бяцхан хүүхдүүдээ хүлээн авч, ангийн үйл ажиллагаагаа сурталчлан таниулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгууллаа.

Тус арга хэмжээний хүрээнд ангийн захирагч мэндчилгээ дэвшүүлж, “Мазаалай ба түүний нөхөд” хүүхэлдэйн театрын хамт олон, “Модерн театр”-ийн жүжигчин Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан Б.Зоригтбаатар нар хүрэлцэн

ирж хүүхэлдэйн театрын үзүүлбэр болон алиалагчийн мэндчилгээ, жонглёртой үзүүлбэрээр бэлэг барив.

Мөн ангийн үйл ажиллагааг сурталчлах аав, ээж нь ямар ажил хийдэг талаар танилцуулах үүднээс зэвсэг, техникийн үзэсгэлэнг дэлгэж, инженерийн бүлгийн үүрэг гүйцэтгэлт, нисдэг тэрэгний талбайд олсоор буух үзүүлбэр, шүхрийн хичээлийн хотхон, гардан тулааны үзүүлэх тоглолтыг сонирхуулав. Төгсгөлд бяцхан үрс өдрийн зоог барьж, хүүхдийн дунд “Шүхэрчин аавын жаргалтай гэр” бүлийн гар зургийн уралдааныг зохион байгуулан хүүхэд бүр гарын бэлгээ ангийн удирдлагаас гардан авсан юм.



ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭВ

Завхан аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Монгол цэрэг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн баярыг тохиолдуулан аймагт үйл ажиллагаагаа явуулж буй Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудыг хамруулсан “Монгол цэрэг энхийн үйлсэд” нээлттэй хаалганы өдөр, сурталчлалгааны арга хэмжээг өнгөрөгч сарын 29-ны өдөр аймгийн төв талбайд зохион байгуулан явуулав. Арга хэмжээний нээлтэд аймгийн Засаг дарга оролцож нийт бие бүрэлдэхүүнд хандаж баяр хүргэж мэндчилгээ дэвшүүлэн, Энхийг сахиулах ажиллагаанд оролцож үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүний төлөөлөлд Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”, “Хүндэт тэмдэг”, аймгийн Засаг даргын “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнасныг гардуулан өглөө. Үргэлжлүүлэн Монгол Улсын баатар,

Армийн генерал Батын Дорж агсны хөшөөнд цэцэг өргөж, Зэвсэгт хүчний 325 дугаар анги, Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүн зэвсэглэл, техник хэрэгсэл, тусгай хэрэгсэл, Энхийг дэмжих ажиллагаанд оролцож ирсэн түүхэн баримтуудаар үзэсгэлэн дэлгэж ард иргэд, хүүхэд залуус сонирхуулав.

Мөн Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн “Бид энхийн цэрэг” урлагийн тоглолт, “Хорлон сүйтгэх бүлэгтэй тэмцэл явуулах, татан гаргах ажиллагаа” сэдвээр үзүүлэх тоглолт, аймгийн Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүний “Гал түймэртэй тэмцэх, аврах, татан гаргах ажиллагаа” сэдэвт үзүүлэх сургууль, “Цэцэн шонхор клуб”-ын бяцхан тамирчдын таквендогийн үзүүлэх тоглолтууд сонирхууллаа.

Дэд хурандаа Г.БАВУУДОРЖ



“ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР”-ӨӨР

Зэвсэгт хүчний 110 дугаар анги

“Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн офицер, ахлагч, ажилтан албан хаагчдын хүүхдүүдийг 5 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авч хүндэтгэл үзүүлээ.

Бяцхан багачууддаа зэвсгийн үзэсгэлэн, үлгэрийн баатруудын мэндчилгээ, хийлдэг тоглоомоор тоглуулж насны ангиллаар “Мөлхөө жаал”, “Бүжгийн тэмцээн”, “Дууны тэмцээн”, “Гар зургийн уралдаан”, “Дартс”-ны тэмцээнүүдийг зохион явуулж авьяас чадвараараа манлайлсан бүх оролцогчдод баяр хүргэж гарын бэлэг гардуулсан.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 26	☁️ 6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	☁️ 27

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,124.00	3,126.0
EUR 🇪🇺	3,340.0	3,365.0
CNY 🇨🇳	466.00	468.50
RUB 🇷🇺	47.00	47.50
JPY 🇯🇵	24.00	24.50
KRW 🇰🇷	2.52	2.54

ЗУРХАЙ



2022.06.02 /ПҮРЭВ ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 3

ЗУНЫ ИЛҮҮ ТЭРГҮҮН САРЫН ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ УЛААН НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Эд мал баялаг төгөлдөр болно
Наран ургах, шингэх:
04.57-20.44

Барилдлага:

Хотол чуулган

Шүтэн барилдлага:

Сэрэхүй

Суудал: Мод

Энэ өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнэс эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, лус тахиx, хүүхэд үрчлэн авах, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, цөөрөм байгуулах, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Балжиннямтай өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, малтай баялаг төгс болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 533,562,282

Эдгэрсэн

Нийт: 504,498,326

Нас барсан

Нийт: 6,315,773

Цахим шууданд

ЦЭНХЭР ДУУЛГАТНУУДАА МАГТАН ДУУЛАВ



Зэвсэгт хүчний 065 дугаар анги

Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 065 дугаар анги 2022 оны 05 дугаар сарын 28-ний өдөр ангийн

байрлалд Зэвсэгт хүчин Энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүллээ. Тус арга хэмжээний үер ангийн нийт бие бүрэлдэхүүн Монгол

Улсын цэргийн тангараг давтан өргөх ажиллагаа болон нийт энхийг сахиулах ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний урлагийн хэсэгчилсэн тоглолтыг бие бүрэлдэхүүнд үзэж сонирхууллаа.

Мөн Зэвсэгт хүчний 065 дугаар ангиас Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэргийн алба хаагчдын дунд гар барилдааны аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж амжилттай оролцсон энхийг сахиулагч цэргийн алба хаагчийг шагнаж урамшууллаа. Тус ангиас Энхийг сахиулах ажиллагаанд давхардсан тоогоор нийт 400 гаруй цэргийн алба хаагч Ирак, Сьерра-леон, Чад, Афганистан, БНЕСУ үүрэг гүйцэтгэжээ.

“ЦЭРГИЙН НЭГДҮГЭЭР ЗЭРГИЙН БЭЛТГЭЛ ҮҮРЭГТЭН БЭЛТГЭХ” СУРГАЛТЫГ АМЖИЛТАЙ ЗОХИОН ЯВУУЛЛАА

Зэвсэгт хүчний 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран “Цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн бэлтгэх сургалт”-ыг 5 дугаар сарын 23-27-ний өдрүүдэд ангийн байрлалд зохион байгууллаа.



Тус сургалтаар арван цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн Р а д и о т е л е г р а ф ч и н , планшетчин мэргэжлээр тус бүр 40 цагийн танхимын хичээл, болоод цэргийн албыг хэвшүүлэх дадлага сургуульд хамрууллаа.

Сургалтыг Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион явуулсан ба өнгөрсөн долоо хоногт төгсөлтийн арга хэмжээ зохион байгуулан Сертификат гардуулан өглөө. Тус бэлтгэл үүрэгтний төгсөлтийн арга хэмжээнд

Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын орлогч дарга хурандаа Э.Эрдэнэпил болон Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга дэд О.Энх-Амар, Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дайчилгааны офицер хошууч Б.Мөнгөн оролцож баяр хүргэлээ.

ШИНЭ АХМАДЫН ӨРГӨӨНИЙХӨӨ НЭЭЛТИЙГ ХИЙВ



Зэвсэгт хүчний 327 дугаар анги

БНМАУ-ын баатар, ЗХУ-ын 4 удаагийн баатар, Маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт

хүчний 327 дугаар анги ахмадын өргөөгөө нээлээ. Нээлтэд ангийн захирагч хурандаа Н.Цэцэнхүү, Дорнод аймгийн Цэргийн штабын

дарга дэд хурандаа О.Ганзориг болон тус ангиас тэтгэвэр чөлөөнд гарсан ахмад дайчид оролцлоо. Энэ үеэр захирагч хурандаа Н.Цэцэнхүү манай хамт олон энэ сургуулийн жилд төлөвлөсөн гол томоохон ажлуудын нэг хэсэг нь ангийн ахмадын өргөөтэй болгох ажил байсан.

Энэ ажил маань биеллээ олж өргөө маань өнөөдөр нээгдсэнээр ахмад настнууд уулзаж ярилцах, санал бодлоо солилцох бас ахмадын зөвлөл үйл ажиллагаагаа тогтмол явуулах нөхцөлийг бүрдүүлсэндээ баяртай байна. Нийт ахмадуудаа эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе гэсэн юм.

“АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ” ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Зэвсэгт хүчний 232 дугаар анги

“Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан “Аз жаргалтай гэр бүл” өдөрлөгийг зохион байгуулж явууллаа. Нээлтийг “Маазигийн дасгалын цаг”-аар эхлүүлж хамтдаа дасгал хийсэн нь хүрэлцэн ирсэн эцэг, эх, хүүхдүүдэд сонирхолтой байлаа. Мөн офицер, ахлагч, ажилтан алба хаагчдын авьяаслаг хүүхдүүд маань хүндэт зочид, аав, ээж, найз, өхөөрдөм бяцхан дүү нартаа “Авьяаслаг багачууд” тоглолт бэлтгэн мэндчилгээ дэвшүүлсэн юм. Хүүхэд багачуудын дунд 0-2 насны ангилалд “Азын бөмбөлөг”, 3-4 насны ангилалд “Гар зургийн уралдаан”, 5-7 насны ангилалд “Унадаг дугуйн” уралдаан, 8-12 насны ангилалд “Даам”-ны тэмцээн, 0-16 насны дунд “Шилдэг бүжигчин”, гэр бүлийн дунд



“Аав ээж би” хөгжөөнт тэмцээнүүдийг тус тус зохион явуулж, өдрийн хоолыг зохион байгууллаа. Төгсгөлд нь ангийн удирдлагууд хүрэлцэн ирсэн эцэг, эх хүүхэд багачуудын гэр бүлд эрүүл энх сайн сайхныг хүсээд тэмцээний шагнал, баярын бэлэг гардуулан өглөө.



Ахмад Ц.ОТГОНСҮРЭН

ТҮҮХТ 20 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ

Зэвсэгт хүчний 325 дугаар анги

2022 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ой, олон улсын энхийг сахиулагчдын баярын өдрөөр Завхан аймгийн Алдархаан сумын харьяат Армийн генерал Батын Доржийн хөшөөнд цэцэг өргөх ёслолын арга хэмжээ зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд Завхан аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал, аймгийн ЗДТГ-ын дарга Г.Мягмарсүрэн, Цэргийн штабын дарга Г.Үнэнбаяр болон Төрийн цэргийн байгууллагуудын удирдлагууд оролцлоо. Түүхт ойн хүрээнд Төрийн цэргийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор нээлттэй



хаалганы өдөрлөгийг зохион байгуулж иргэд залуучууд, өсвөр үеийнхэнд эх орноо хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, томоохон ажлыг зохион байгууллаа. Нээлттэй хаалганы үеэр арга хэмжээнд оролцож буй байгууллагуудын алба хаагч

нарын бэлтгэсэн урлагийн номер, үзүүлэхийн зэрэгцээ энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэргийн алба хаагч бүр 1 ширхэг мод тарьж ангийн байрлалыг моджуулах ажилд өөрсдийн хувь нэмрээ орууллаа.

ЭХ ҮРСИЙН БАЯРЫН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн удирдлага, хамт олон “Covid-19” цар тахлаас сэргийлэх үүднээс сүүлийн хоёр жилд зохион байгуулагдаагүй байсан Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр буюу “Эх үрсийн баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүллээ. Уг ажиллагааг нээж ангийн захирагч

Г.Чулуунзагд “Эх орон, энэ нутгийн ирээдүй, эцэг эхийн эрдэнэ болсон хүүхэд багачуудаа баярлуулах сайхан завшаан олдсонд таатай байна” хэмээн эх үрсийн баярын мэнд дэвшүүлээ. Мөн Агаарын командлалын штабын дарга бригадын генерал Б.Эрдэнэбат

хүрэлцэн ирсэн бүх ээжүүд болон энхрий бяцхан хүүхдүүддээ агаарын цэргийн командлалын удирдлага хамт олныг төлөөлж баярын мэндчилгээ дэвшүүлсэн юм. Энэ үеэр ангийн ССХА-аас зохион байгуулсан урлагийн номер болон дугуйгаар, байрлуулсан туг сүлжиж тойрох, нэг удаагийн аягаар пирамид хэлбэрээр өрж буцаан хураах, асуулт хариултын “АХА” тэмцээнийг насны ангилал тус бүрд зохион байгуулж шилдгүүдийг нь шалгаруулсан юм. Ангийн захирагчийн тушаалаар эх үрсийн баярын өдөр офицер, ахлагч, ажилтан алба хаагчдынхаа 16 нас хүртэлх нийт 250 хүүхдэд баярын бэлэг гардуулсан бөгөөд хүрэлцэн ирсэн хүүхэд багачууд энэ үеэр өөрсдийн авьяас чадварыг нээж дуу, шүлэг, хөгжим тоглож сонирхууллаа.

ТОЛБО НУУРЫН ЭРЭГТ ХҮҮХДҮҮДИЙН ХАМТ ХӨГЖИЛДӨВ

Зэвсэгт хүчний 331 дүгээр анги

Ангийн удирдлага, хамт олон, ангийн эмэгтэйчүүдийн зөвлөл “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан алба хаагчдынхаа гэр бүл, үр хүүхдүүдийг Баян-Өлгий аймгийн үзэсгэлэнт Толбо нуурын эрэгт хүлээг авч, баярын арга хэмжээг зохион байгууллаа.

Арга хэмжээг нээж ангийн захирагч хурандаа Ц.Буянтогтох мэндчилгээ дэвшүүлж, Үлээвэр найрал хөгжмийн салааны бүрэлдэхүүн дуу хуураар мэндчилгээ өргөж, авьяаслаг бяцхан багачуудын нэгдсэн урлагийн тоглолт үзүүллээ. Энэ үеэр ангийн эмэгтэйчүүд хүүхэд багачуудаа мини хуушуур, шорлог, амтат бялуур, үзэм, цацарганын шүүсээр үйлчилж, ангийн удирдлагууд хүүхэд бүрд баярын бэлэг гардуулан өглөө.

Ийнхүү хүүхдийн баярыг угтан хамт олон, үр хүүхдүүдтэйгээ нэг өдрийг баяр жаргал, дурсамжаар дүүрэн өнгөрүүлж, багачуудаа баярлууллаа.

Ахлах дэслэгч Б.ГЭРЭЛТ-ОД

